

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/282/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naramchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261885 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261885 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/827
танай _____-ны № _____-т

「ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.БАУЫРЖАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- "Дэл-Оюу Дөл" ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлээс 349,900.0 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн зөрчилд өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, мөн тайланд онд төлөх 385,000.0 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн;
- Гэрээт харуул, хамгаалалтын албыг эрхлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 33,550.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн баримт бичгийг холбогдох хууль, журам, зааврын дагуу үнэлгээ хийгээгүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар баталсан журамд нийцээгүй бөгөөд

санхүүгийн тайлагналын “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 189,828.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас үнэ төлбөргүй нийлүүлсэн 102,687.2 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудал

Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,574,370,574.13	1,579,044,054.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,900.00	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	3,900.00	-
31210	Төгрөг	3,900.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	3,900.00	-
33	АВЛАГА	1,569,336,298.13	1,576,283,985.50
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	23,982,385.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13,980,600.00	-
33500	Бусад авлага	3,054,098.13	-
33510	Байгууллагаас авах авлага	3,054,098.13	-
33600	Зээлийн авлага	1,552,301,600.00	1,552,301,600.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,552,301,600.00	1,552,301,600.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	1,552,301,600.00	1,552,301,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,030,376.00	2,760,069.00
35400	Хангамжийн материал	5,030,376.00	2,760,069.00
35410	Бичиг хэргийн материал	2,208,080.00	1,395,870.00
35420	Аж ахуйн материал	217,800.00	52,800.00
35470	Бусад хангамжийн материал	2,604,496.00	1,311,399.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,325,981,764.32	3,235,508,734.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,325,981,764.32	3,235,508,734.16
39200	Биет хөрөнгө	3,255,197,157.49	3,164,865,294.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,167,535.00	3,500,167,535.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(465,731,932.31)	(533,685,189.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,850,000.00	67,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(100,434,583.36)	(27,725,833.17)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	237,109,612.00	232,366,272.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(153,393,293.60)	(127,176,423.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,083,416.88	72,107,540.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,937,778.16)	(28,874,600.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,387,934.80	12,801,884.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,903,753.76)	(11,015,892.20)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	70,784,606.83	70,643,440.00
39301	Программ хангамж	17,309,090.91	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,309,090.91)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	77,168,440.00	71,413,440.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(6,383,833.17)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,900,352,338.45	4,814,552,788.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,241,598.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,241,598.01
41300	Өглөг	-	5,241,598.01
41310	Ажилчидтай холбоотой өглөг	-	5,241,598.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,900,352,338.45	4,809,311,190.65
51	Засгийн газрын хувь оролцоо	4,900,352,338.45	4,809,311,190.65

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал	1,474,849,925.14	1,474.849,925,14
511001	Өмч-Төрийн	1,474,849,925.14	1,474,849,925.14
51200	Хуримтлагдсан үр дүн	796,568,333.49	705,527,185.69
51210	Өмнөх үеийн үр дүн	919,365,128.80	817,690,020.92
51220	Тайлант үеийн үр дүн	(122,796,795.31)	(112,162,835.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,628,934,079.82	2,628,934,079.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,900,352,338.45	4,814,552,788.66

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,697,487,150.00	3,688,698,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	103,512,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	103,512,200.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	103,512,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	102,687,200.00
140020	Бусад орлого	-	825,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,697,487,150.00	3,585,186,470.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,656,930,460.00	3,407,833,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,656,930,460.00	3,407,833,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,556,690.00	177,353,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,319,200.00	175,848,170.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	237,490.00	1,505,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,820,283,945.31	3,742,657,755.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,820,283,945.31	3,742,657,755.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,243,867,285.86	1,933,203,676.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,906,628.48	963,705,644.84
210101	Үндсэн цалин	507,854,662.15	582,811,780.96
210102	Нэмэгдэл	90,129,240.50	173,689,639.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,219,464.54	129,536,478.73
210104	Урамшуулал	47,703,261.29	77,667,745.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,681,714.63	206,785,683.57
210201	Тэтгэврийн даатгал	62,885,981.33	150,027,883.49
210202	Тэтгэмжийн даатгал	11,967,800.00	14,189,500.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,898,408.66	7,094,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,055,324.64	7,094,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,874,200.00	28,378,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,662,502.53	61,613,558.33
210301	Гэрэл, цахилгаан	23,431,805.36	17,414,308.18
210302	Түлш, халаалт	13,247,313.18	22,214,866.61
210303	Цэвэр, бохир ус	20,983,383.99	21,984,383.54
2104	Хангамж, бараа материалын зардал	22,405,121.00	29,506,642.00
210401	Бичиг хэрэг	5,631,574.00	6,278,920.00
210402	Тээвэр, шатахуун	1,020,423.00	151,594.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,406,451.00	11,409,215.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,346,673.00	9,001,916.00
210408	Эд хогшил, акталсны зардал	-	2,664,997.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,543,500.00	1,390,000.00
210604	Урсгал засвар	2,543,500.00	1,390,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,999,655.00	350,379,571.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,993,755.00	334,534,571.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	14,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	425,000.00

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,900.00	79,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	902,000.00	441,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,668,164.22	319,822,576.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,338,600.00	184,866,096.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,329,564.22	134,956,480.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	576,416,659.45	1,809,454,079.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,644,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	6,644,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	576,079,169.45	1,802,810,079.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	576,079,169.45	1,801,305,079.33
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	237,490.00	1,505,000.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(122,796,795.31)	(53,959,085.40)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	58,203,749.83
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	58,203,749.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(122,796,795.31)	(112,162,835.23)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,697,587,150.00	3,599,992,070.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	825,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	825,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	825,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,697,487,150.00	3,599,167,070.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,656,930,460.00	3,407,833,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,656,930,460.00	3,407,833,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,556,690.00	191,333,770.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,319,200.00	189,828,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	237,490.00	1,505,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,697,587,150.00	3,599,995,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,697,587,150.00	3,599,995,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,107,189,890.55	1,790,541,890.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,087,727.69	987,688,030.34
210101	Үндсэн цалин	506,305,523.86	606,794,166.46
210102	Нэмэгдэл	90,129,240.50	173,689,639.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,219,464.54	129,536,478.73
210104	Урамшуулал	50,433,498.79	77,667,745.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,757,181.33	177,368,300.00
210201	Тэтгэврийн даатгал	62,885,981.33	120,610,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,967,800.00	14,189,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,715,900.00	7,094,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,251,900.00	7,094,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,935,600.00	28,378,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,662,502.53	61,613,558.33
210301	Гэрэл, цахилгаан	23,431,805.36	17,414,308.18
210302	Түлш, халаалт	13,247,313.18	22,214,866.61
210303	Цэвэр, бохир ус	20,983,383.99	21,984,383.54
2104	Хангамж, бараа материалын зардал	20,456,672.00	27,644,961.00
210401	Бичиг хэрэг	3,845,700.00	7,275,650.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,406,451.00	11,409,215.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,204,521.00	8,960,096.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,583,700.00	1,390,000.00
210604	Урсгал засвар	2,583,700.00	1,390,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183,303,507.00	345,008,271.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,297,607.00	329,163,271.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	14,900,000.00

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	-	425,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,900.00	79,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	902,000.00	441,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,338,600.00	189,828,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,338,600.00	189,828,770.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	590,397,259.45	1,809,454,079.33
	Бусад урсгал шилжүүлэг	-	6,644,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	6,644,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	590,397,259.45	1,802,810,079.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	576,079,169.45	1,801,305,079.33
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,218,090.00	1,505,000.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-3,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-3,900.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,900.00	3,900.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,900.00	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	935,621,694.71	5,039,405,699.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(16,256,565.91)	(16,256,565.91)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	919,365,128.80	5,023,149,133.76
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(122,796,795.31)	(122,796,795.31)
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	796,568,333.49	4,900,352,338.45
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	796,568,333.49	4,900,352,338.45
7	Тайлант үеийн үр дүн	-	-	21,121,687.43	21,121,687.43
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	817,690,020.92	4,921,474,025.88
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(112,162,835.23)	(112,162,835.23)
10	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	705,527,185.69	4,809,311,190.65

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,504,145,400.00	1,607,357,120.67	1,896,788,279.33	45.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,504,145,400.00	1,607,357,120.67	1,896,788,279.33	45.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,401,189,300.00	1,600,713,120.67	1,800,476,179.33	47.1%
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,418,946,700.00	987,688,030.34	431,258,669.66	69.6%
210101	Үндсэн цалин	684,150,900.00	606,794,166.46	77,356,733.54	88.7%
210102	Нэмэгдэл	468,110,900.00	173,689,639.80	294,421,260.20	37.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	186,867,800.00	129,536,478.73	57,331,321.27	69.3%
210104	Урамшуулал	79,817,100.00	77,667,745.35	2,149,354.65	97.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатга	177,368,300.00	177,368,300.00	-	100.0%
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	120,610,500.00	120,610,500.00	-	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	14,189,500.00	14,189,500.00	-	100.0%
210203	ҮОМШ-ний даатгал	7,094,700.00	7,094,700.00	-	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	7,094,700.00	7,094,700.00	-	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	28,378,900.00	28,378,900.00	-	100.0%
2103	Байр ашиглалттай хол тогтмол зардал	85,777,100.00	61,613,558.33	24,163,541.67	71.8%
210301	Гэрэл, цахилгаан	28,946,100.00	17,414,308.18	11,531,791.82	60.2%
210302	Түлш, халаалт	23,578,400.00	22,214,866.61	1,363,533.39	94.2%
210303	Цэвэр, бохир ус	33,252,600.00	21,984,383.54	11,268,216.46	66.1%
2104	Хангамж, бараа материалын зард	33,984,200.00	27,644,961.00	6,339,239.00	81.3%
210401	Бичиг хэрэг	7,382,700.00	7,275,650.00	107,050.00	98.5%
210402	Тээвэр, шатахуун	3,938,500.00	-	3,938,500.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэт	14,488,700.00	11,409,215.00	3,079,485.00	78.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	8,174,300.00	8,960,096.00	(785,796.00)	109.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зар	13,935,500.00	1,390,000.00	12,545,500.00	10.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	-	10,000,000.00	0.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	202,000.00	-	202,000.00	0.0%
210604	Урсгал засвар	3,733,500.00	1,390,000.00	2,343,500.00	37.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	1,671,177,500.00	345,008,271.00	1,326,169,229.00	20.6%
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	1,651,714,400.00	329,163,271.00	1,322,551,129.00	19.9%
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	15,800,000.00	14,900,000.00	900,000.00	94.3%
210803	Даатгалын Үйлчилгээ	426,000.00	425,000.00	1,000.00	99.8%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,300.00	79,000.00	24,300.00	76.5%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	48,900.00	-	48,900.00	0.0%

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	884,900.00	441,000.00	443,900.00	49.8%
210807	Газрын төлбөр	2,200,000.00	-	2,200,000.00	0.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,956,100.00	6,644,000.00	96,312,100.00	6.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,956,100.00	6,644,000.00	96,312,100.00	6.5%
213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм	92,869,700.00	-	92,869,700.00	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	10,086,400.00	6,644,000.00	3,442,400.00	65.9%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,504,145,400.00	1,607,353,220.67	1,896,792,179.33	45.9%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,504,145,400.00	1,606,528,220.67	1,897,617,179.33	45.8%
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,504,145,400.00	1,606,528,220.67	1,897,617,179.33	45.8%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	825,000.00	(825,000.00)	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	825,000.00	(825,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,900.00	(3,900.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35.00	35.00	-	100.0%
62000	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
62000	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	-	100.0%

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	191,333,770.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	191,333,770.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	189,828,770.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	189,828,770.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	189,828,770.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,505,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,505,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт	-	1,505,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	191,333,770.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	191,333,770.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	189,828,770.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,505,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 1,139.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 302.5 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 485.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага, 349.90 сая төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

3.1.Аудитаар нийт 302.5 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайлан дахь Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тодруулга тайлангаас 4,600.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	4,600.0	-	-	1	4,600.0	1	4,600.0	-	-
Бараа материалын тодруулга тайлан дахь акталсан хэсгийн 2,665.0 мянган төгрөгийн зарлагыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 210409 дансаар тайлагнаагүй.	1	2,665.0	1	2,665.0	-	-	1	2,665.0	-	-
Мөнгөн гүйлгээний тайлангийн Нийт цэвэр мөнгөн гүйлгээ 996.3 мянган төгрөгөөр зөрсөн.	1	996.3	1	996.3	-	-	1	996.3	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд тайлант хугацаанд худалдан авсан 102,687.2 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ хэсэгт тайлагнаагүй Үйл ажиллагааны зардлаар харуулсан.	1	102,687.2	-	-	1	102,687.2	1	102,687.2	-	-

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн улсын төсвөөс санхүүжих дүн мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээс 16,013.8 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан. Өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.9 мянган төгрөгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнаагүй.	1	16,013.8	1	16,013.8	-	-	1	16,013.8	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг хамт тайлагнасан. Мөн Нэмэлт санхүүжилтийн орлогыг И-хуулгаас 1,505.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,505.0	1	1,505.0	-	-	1	1,505.0	-	-
Төсвийн гүйцэтгэлийн зардлыг И-хуулгатай тулгахад 2104 хангамж материал бүлэг 66.5 мянган төгрөгөөр, 210801 БГАУТХ зардал 450.0 мянган төгрөгөөр, 213209 тэтгэмж урамшуулал 6,144.0 мянган төгрөгөөр зөрсөн.	1	6,660.5	1	6,660.5	-	-	1	6,660.5	-	-
Санхүүгийн байдлын тайлангийн бусад биет бус хөрөнгийн дүн 66,813.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүн 71,413.4 мянган төгрөг буюу 4,600.0 мянган төгрөгийн зөрүүтэй.	1	4,600.0	1	4,600.0	-	-	1	4,600.0	-	-
Санхүү байдлын тайлангийн эргэлийн тус хөрөнгийн дүн 3,235,508.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүн 3,240,108.7 мянган төгрөг байна.	1	4,600.0	1	4,600.0	-	-	1	4,600.0	-	-
Тайлант онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас үнэ төлбөргүй ирсэн 102,687.2 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан байна.	1	102,687.2	-	-	1	102,687.2	1	102,687.2	-	-

Нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүн нь 1,063,519.1 мянган төгрөг байгаа бөгөөд татварын байгууллагад илгээсэн Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан/ТТ-11/-д Хөдөлмөрийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах зөвлөлийн гишүүдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон 29,040.0 мянган төгрөгийг тусгаагүй, 1,034,479.1 мянган төгрөгөөр тайлагнасан	1	29,040.0	1	29,040.0	-	-	1	29,040.0	-	-
Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Б.Хурцэцэгийн төрийн албанаас халсан шийдвэрийг хүчингүй болгож, урьд эрхэлж байсан албан тушаалд эргүүлэн томилсон. мөн Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс У.Сосорбурамыг Төрийн албанаас чөлөөлсөн тушаалыг хууль зүйн үндэслэлгүйд тооцсон шийдвэрийг үндэслэн Б.Хурцэцэг, У.Сосорбурам нарт 30,021.8 мянган төгрөгийг олгохоор тооцож, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл, орлогын албан татварыг суутган 23,982.4 мянган төгрөгийг олгосон байна. Энэ тооцоо нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд тусгагдаагүй.	1	23,984.4	1	23,984.4	-	-	1	23,984.4	-	-
2024 оны 7-р сард Б.Амаржаргалд олгосон ээлжийн амралтын 2,498.7 мянган төгрөгийг олговол зохих дүнд оруулаагүй орхигдуулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон Хувь орлогын албан татварын тайланд тусгаагүй	1	2,498.7	1	2,498.7	-	-	1	2,498.7	-	-
Дүн	13	302,538.1	10	92,563.7	3	209,974.4	13	302,538.1	-	-

3.2. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 736.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 385.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 349.9 сая төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар "Дэл-Оюу Дөл" ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант хугацаанд 350,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэхээс 349,900.0 мянган төгрөгийн зээлийн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.	1	349,900.0	-	-	-	-	-	-	1	349,900.0
"Дэл-Оюу Дөл" ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу 385,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн байна.	1	385,000.0	-	-	1	385,000.0	-	-	-	-
Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, хувь хүмүүст олгосон ажлын хөлс 7,104.0 мянган төгрөгийн орлогоос 888.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.	1	888.0	1	888.0	-	-	-	-	-	-
Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн амралтын цалинг буруу тооцоолсноос 1 хүнд 511.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.	1	511.3	1	511.3	-	-	-	-	-	-
Дүн	4	736,299.3	2	1,399.3	1	385,000.0	-	-	1	349,900.0

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3.Нийцлийн аудиттай холбоотой нийт 100.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 183 мэдээллээс 176 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба хугацаа болоогүй 5 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Мөн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 18,000.0 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 43,409.8 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээллээгүй байна.	1	61,409.8	1	61,409.8	-	-
Дүн	1	61,409.8	1	61,409.8	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Гэрээт харуул, хамгаалалтын албыг эрхлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХБХХЕГ/20240203001 дугаартай, 33,550.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн баримт бичгийн үнэлгээг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар журам"-ын дагуу хийгээгүй байна.	1	33,550.2	1	33,550.2	-	-
Оюуны ялгаатай хөгжилтэй хүүхэд залуучуудыг спортоор дамжуулан хөгжүүлэх "Хамтарсан сургууль" хөтөлбөр хэрэгжүүлэх ХБХХЕГ/20240103018 дугаартай, 196,200.0 мянган төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагаа явуулж, гэрээ байгуулахдаа, гүйцэтгэлийн баталгааны 5,886.0 мянган төгрөгийг гаргуулан аваагүй гэрээ байгуулсан.	1	5,886.0	1	5,886.0	-	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайланг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар баталсан журмын маягт 1 болон 2-ын дагуу гаргаагүй.	1	-	1	-	-	-
Дүн	3	39,436.2	3	39,436.2	-	-
Нийт дүн	4	100,846.0	4	100,846.0	-	-

